**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 09 өдөр          Дугаар А/396          Хэрлэн сум

Төрөлжсөн асрамжийн газарт
асруулагчийг хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 2 дугаар багийн харьяат И.Эрдэнэзул, И.Отгонжаргал нарыг Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны “Вербист” хүүхдийн төвийн асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2.И.Эрдэнэзул, И.Отгонжаргал нарыг асрамжийн газарт хүргэх ажлыг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга (М.Шүрэнцэцэг)-д, хүүхдийн асуудлаар эргэх холбоотой ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Х.Уртнасан)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/240 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА          Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Docment Захирамж А4-2022

231010889